


2020-2021 оны хичээлийн жилийн хаврын улирлын клубүүдийн тайлан хэлэлцэх хурал цахимаар боллоо.

ШУТИС-ийн оюутны мэргэжлийн болон сайн дурын клубүүдийн тайлан хэлэлцэх хурал 2021 оны 05 дугаар сарын 21 нд TEAMS-ээр зохион байгуулагдлаа.



Цар тахлын улмаас цахим хичээллэж буй энэ цаг үед ШУТИС-ийн оюутны клубийн үйл ажиллагаа тасралтгүй сайн явагдсан нь хийсэн ажлаа танилцуулж буй тайлангаас тодорхой харагдаж байна.

Тус тайлангийн хуралд мэргэжлийн Sys&Cotheach клуб, Inspirashion клуб, CCS клуб, Звёздочка клуб, сайн дурын Empowerment клуб, Соёмбо клуб, Багшийн туслах оюутан клуб, Хятад хэлний клуб, Speaking клубүүд тайлангаа хэлэлцүүлээ. БуХС-ийн ОНХА мэргэжлийн оюутнууд шинэ PataiaR клуб байгуулснаа танилцууллаа.



Тайлангийн хурлыг дүгнэхээр ОСҮА-ны дарга Н.Санчирбаатар, ОСҮА-ны ахлах мэргэжилтэн, доктор (Ph.D) Д.Цогзолмаа, БуХС-ийн НУС-ын багш Д.Ариунтогс нар ажилласан.

Тайлан хэрэлцүүлсэн клубийн шилдэг оюутнуудад журмын дагуу кредит урамшуулал олгохоос гадна цахим үйл ажиллагааг сайн зохион байгуулсан клубийн зөвлөх багш болон клуб тус бүрт талархал олгов.

ШУТИС-ийн сайн дурын болон мэргэжлийн клубүүдийн оюутнуудаас төгсөж буй дараах оюутнуудыг ШУТИС-ийн шилдэг болон тэргүүний төгсөгчөөр тодорхойлон шагнууллаа.

Үүнд Шилдэг төгсөгчөөр “Соёмбо” клубийн тэргүүн Н.Баяраа ГУУС-ийн Геодези мэргэжлийн төгсөгч,

Тэргүүний оюутан

1. Хятад хэлний клубийн гишүүн Номт овогтой Дашзүмбэр ГХС-ийн Техник технологийн орчуулга мэргэжлийн төгсөгч

2. “Sys&CoTech” клубийн гишүүн Сумъяа овогтой Бямбадалай МХТС-ийн системийн аюулгүй байдал мэргэжлийн төгсөгч

3. “Соёмбо” клубийн дэд тэргүүн Б.Баяржавхлан ГУУС-ийн Геодези мэргэжлийн төгсөгч

ШУТИС-ийн Оюутны холбооны шилдэг төгсөгчөөр

1. Б.Минжинсор ОСҮА-ны туслах сайн дурын оюутан, БТОК-ийн нарийн бичгээр ажиллаж байсан. ҮТС-ийн хүнс үйлдвэрлэлийн технологич инженер мэргэжлийн төгсөгч

2. А.Даваамөнх ШУТИС Эрдмийн Индэр клубийн гишүүн, БУХС-ийн Харилцаа холбооны менежмент мэргэжлийн төгсөгч нар шагнуулсан.

Клубүүдийн багш оюутнууддаа сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт хүсэн ерөөе.

Оюутны соёл, үйлчилгээний алба